



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: СНАГ-2024/19/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamj@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхжин
Утас: 261628 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмонгол хөлөг Аудит"
ХХК-ийн захирал: С.Тунгалаг
Утас: 99061771, 7000177

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Монголын цахилгаан холбоо ХК, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	14
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	22
5.2 Албан шаардлага	23
5.3 Зөвлөмж.....	28
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	31
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	31
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	35
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	41

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
СХЭУГ	Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар
СЯ	Сангийн яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын их хурал
УУББ	Уул уурхайн бүтээгдэхүүний бирж
ХК	Хувьцаат компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШУ	Хяналт- шинжилгээ, үнэлгээ
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
МЦХ	Монголын цахилгаан холбоо



МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЧИНБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр
Утас: 26 04 37, Факс: 51-26-42 30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/834

танай _____ -ны № _____ -г

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийт илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 15,678.9 сая төгрөгөөр давсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 зүйлийн 11.8, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 11,577.8 сая төгрөг;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 4,113.5 сая төгрөг;
- Орлогыг мөнгөн сууриар бүртгэж тайлагнасан 121.2 сая төгрөг;
- Цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг зөрүүтэй бүртгэж тайлагнасан 72.4 сая төгрөг;
- Ашиглаж байгаа бараа материал болон үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй 0.9 сая төгрөг;

Асуудлыг онцолсон хэсэг

Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт 25,870,276 ширхэг энгийн хувьцааны 94.7 хувь буюу 24,499,287 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг 4005 гадаад дотоодын иргэд, хуулийн этгээд эзэмшдэг нээлттэй хувьцаат компани бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгж хувьцааны хаалтын ханш 461.1 төгрөг, зах зээлийн үнэлгээ 11,928.8 сая төгрөг байна.

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 2022 оны 244 дүгээр тогтоолоор Монголын цахилгаан холбоо ХК-ийн 34 хүртэлх хувийг олон нийтэд нээлттэй худалдахаар шийдвэрлэснийг, 2023 оны 382 дугаар тогтоолоор хувьцааны арилжааг 2023 оны 4 дүгээр улиралд зохион байгуулахаар өөрчлөлт оруулсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны “Нэмж гаргаж буй үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай” 2024 оны 44 дүгээр тогтоолоор нийтэд санал болгон нэмж гаргаж буй 11,249,855 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийг нь 500 /таван зуу/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдах зөвшөөрлийг олгожээ.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 185 дугаар хурлын тогтоолын 1-д 2022 оны цэвэр ашиг болох 10.7 сая төгрөгөөс ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн байна.

Аудитын гол асуудал

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 192 дугаар тогтоолын 4-т Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Жигжиджавын гудамжинд байрлалтай 779 м.кв талбайтай, эрхийн улсын бүртгэлийн Э-2202005542 дугаартай, 4,627.3 сая төгрөгийн зах зээлийн үнэ бүхий газрыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-д төлөх богино хугацаат өр төлбөрт тооцон шилжүүлэх тогтоолыг баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 189 дүгээр тогтоолын 1-т компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг хангалттай, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн байна.

Компани нь 2023 онд 30 үндсэн зорилгын хүрээнд 100 зорилтыг хэрэгжүүлэхээр 277 арга хэмжээг төлөвлөсөн ба үйл ажиллагааны тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт аудитын явцад гараагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	308,008,601.51	751,782,919.75
1.1.2	Дансны авлага	2,376,672,393.18	3,945,046,395.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	5,823,290.88	3,223,219.87
1.1.4	Бусад авлага	1,494,072,787.88	1,867,954,083.17
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	1,500,000,000.00	1,500,000,000.00
1.1.6	Бараа материал	3,216,553,507.21	3,437,925,422.78
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	472,470,179.60	2,303,367,881.95
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	9,373,600,760.26	13,809,299,922.52
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	26,224,751,163.31	38,857,706,205.67
1.2.2	Биет бус хөрөнгө	13,305,392,420.85	15,193,688,594.77
1.2.3	Биологийн хөрөнгө	10,455,000.00	
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		155,212,100.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	125,863,679.08	
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	39,666,462,263.24	54,206,606,900.44
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	49,040,063,023.50	68,015,906,822.96
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	4,109,183,748.77	6,109,423,314.99
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	356,649,067.21	835,291,129.79
2.1.1.4	НДШ-ийн өглөг	72,889,034.13	428,662.48
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг	96,295,888.11	270,592,190.16
2.1.1.7	Ноогдол ашгийн өглөг	146,197,187.50	146,169,613.66
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	692,919,362.08	468,260,758.38
2.1.1.9	Нөөц /богино хугацаат өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,526,886,556.11	2,734,177,481.75
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,001,020,843.91	10,564,343,151.21
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		1,209,000,000.00
2.1.2.2	Нөөц /урт хугацаат өр төлбөр/		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		1,503,973,693.32
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	4,370,849,753.20	4,370,849,753.20
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,370,849,753.20	7,083,823,446.52
2.2	Өр төлбөрийн нийт дүн	12,371,870,597.11	17,648,166,597.73
2.3	Эздийн өмч		



Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3.1	Өмч: - төрийн	2,449,928,700.00	2,449,928,700.00
2.3.2	- хувийн	137,098,889.00	137,098,889.00
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,247,555,045.10	14,088,188,462.23
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	8,247,270,172.39	8,247,270,172.39
2.3.9	Хуримтлагдсан ашиг	20,586,339,619.90	25,445,254,001.61
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	36,668,192,426.39	50,367,740,225.23
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	49,040,063,023.50	68,015,906,822.96

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	17,394,684,301.17	18,938,223,103.01
2	Борлуулалтын өртөг	(14,343,851,233.06)	(14,704,824,592.67)
3	Нийт ашиг (алдагдал)	3,050,833,068.11	4,233,398,510.34
4	Түрээсийн орлого	704,504,002.98	649,693,435.66
5	Хүүгийн орлого	149,125,182.48	164,718,433.72
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	487,292,708.78	514,144,459.22
9	Борлуулалт, маркетингийн зардал	(1,153,577,454.91)	(1,448,188,458.72)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(2,624,476,664.75)	(2,979,884,438.96)
11	Санхүүгийн зардал	(96,295,888.11)	(225,432,665.67)
12	Бусад зардал	(561,743,958.54)	(869,065,134.37)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	15,362,389.45	(1,994,038.18)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	63,090,908.27	78,681,818.18
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	34,114,293.76	116,071,921.22
19	Орлогын татварын зардал	(23,414,254.79)	(87,214,478.89)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	10,700,038.97	28,857,442.33
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	10,700,038.97	28,857,442.33
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		8,840,633,417.13
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	10,700,038.97	8,869,490,859.46
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	10,700,038.97	8,869,490,859.46



2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгсгөвөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	999,486,536.10	8,247,270,172.39	22,658,662,993.23	34,492,447,290.72
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(2,083,023,412.30)	(2,083,023,412.30)
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	10,700,038.97	10,700,038.97
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	4,248,068,509.00	-	-	4,248,068,509.00
1	2023 оны 1-р сарын 01-ний үлдэгдэл	2,587,027,589.00	5,247,555,045.10	8,247,270,172.39	20,586,339,619.90	36,668,192,426.39
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	4,830,056,939.38	4,830,056,939.38
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	28,857,442.33	28,857,442.33
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	8,840,633,417.13	-	-	8,840,633,417.13
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,587,027,589.00	14,088,188,462.23	8,247,270,172.39	25,445,254,001.61	50,367,740,225.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн(+)	22,214,907,800.00	18,460,291,583.53
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	16,385,808,286.85	16,311,807,883.10
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	5,829,099,513.15	2,148,483,700.43
1.2	Мөнгөн зарлагын дүн(-)	(15,916,181,727.46)	(17,049,666,170.33)
	Ажиллагчдад төлсөн	(5,595,715,573.66)	(5,843,769,120.81)
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(1,562,035,284.71)	(1,667,772,652.46)
	Бараа материал худалдан авахад төлсөн	(3,170,282,874.24)	(3,454,040,774.14)
	Ашиглалтын зардалд төлсөн	(2,939,341,701.41)	(3,085,791,663.03)
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(353,297,320.93)	(428,487,596.34)
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	(945,788,489.79)	(1,252,536,843.21)
	Даатгалын төлбөрт төлсөн	(34,620,582.72)	(26,859,912.27)
	Бусад мөнгөн зарлага	(1,315,099,900.00)	(1,290,407,608.07)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,298,726,072.54	1,410,625,413.20
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн(+)	98,271,270.56	243,137,265.04
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	69,399,961.56	221,881,363.64
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	22,548,209.00	13,172,100.00
	Хүлээн авсан хүүгийн орлого	6,323,100.00	8,083,801.40
	Хүлээн авсан ноогдол ашиг		
	Бусад орлого.		
2.2	Мөнгөн зарлагын дүн(-)	(7,072,759,470.56)	(1,210,066,103.00)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(5,072,759,470.56)	(1,210,066,103.00)
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
	Бусад зарлага.	(2,000,000,000.00)	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,974,488,200.00)	(966,928,837.96)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн(+)	25,792,930.83	659,786.87
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Валютын зөрүүний орлого	25,792,930.83	385,258.42
	Бусад орлого		274,528.45
3.2	Мөнгөн зарлагын дүн(-)	(25,796,432.14)	(582,043.87)
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг	(25,771,050.00)	
	Валютын зөрүүний алдагдал	(25,382.14)	(554,573.87)
	Бусад зарлага		(27,470.00)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,501.31)	77,743.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(675,765,685.36)	443,774,318.24
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	983,774,286.87	308,008,601.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	308,008,601.51	751,782,919.75

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

д.д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2023		Өөрчлөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Үйлчилгээний орлого	20,938,207.5	20,790,073.7	(148,133.8)	99.3
	а/ Үндсэн үйл ажиллагаа	20,699,207.5	20,262,192.6	(437,014.9)	97.9
	б/ Үндсэн бус үйл ажиллагаа	239,000.0	527,881.1	288,881.1	220.9
2	НИЙТ ОРЛОГО	20,938,207.5	20,790,073.7	(148,133.8)	99.3
3	НИЙТ ЗАРДАЛ	20,898,188.6	20,671,144.1	(227,044.6)	98.9
	Үүнээс: Удирдлагын зардал	2,314,967.0	2,979,884.4	664,917.5	128.7
4	Татварын өмнөх ашиг	40,018.9	118,929.6	78,910.8	297.2
5	Цэвэр ашиг /алдагдал/	10,018.9	28,857.4	18,838.6	288.0
6	Төсвийн төлбөрт нийт дүн	3,227,100.0	3,616,512.2	389,412.2	112.1
	а/Орлогын татвар	30,000.0	90,072.2	60,072.2	300.2
	б/ НӨАТ	1,200,000.0	1,213,231.0	13,231.0	101.1
	в/НДШ	1,550,000.0	1,667,772.7	117,772.7	107.6
	г/Хүн амын орлогын татвар	400,000.0	543,926.9	143,926.9	136.0
	д/Үл хөдлөхийн татвар	24,000.0	31,455.3	7,455.3	131.1
	е/Гаалийн татвар	-	-	-	0.0
	ж/Тээврийн хэрэгслийн татвар	8,100.0	3,752.2	(4,347.8)	46.3
	и/Бусад татвар /Газрын төлбөр/	15,000.0	66,302.0	51,302.0	442.0
7	Төрийн өмчийн ногдол ашигт	-	-	-	0.0
8	Нийт ажиллагсдын тоо	690	516	(174.0)	74.8
9	Нийт цалингийн сан	6,972,070.0	6,154,208.5	(817,861.5)	88.3
10	Нэг ажилчны дундаж цалин	842.0	993.9	151.9	118.0
13	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал	1.00	0.99	-	99.6
14	Хөрөнгө оруулалт	3,468,555.2	1,180,246.0	(2,288,309.1)	34.0
15	НИЙТ АВЛАГА	2,739,999.7	5,841,069.8	3,101,070.1	213.2
16	НИЙТ ӨГЛӨГ	7,132,047.9	17,693,354.9	10,561,307.0	248.1
	Үүнээс: Богино хугацаат өглөг	7,132,047.9	11,818,531.4	4,686,483.6	165.7



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Монголын цахилгаан холбоо ХК, түүний үйл ажиллагаа

Монголын цахилгаан холбоо ХК нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангаж, нийгэм эдийн засгийн үүрэг хариуцлагыг хүлээх зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулдаг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг компанийн дүрэмд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Иргэд бизнес, засгийн газрын болон бусад хэрэглэгчдэд өндөр чанартай, харилцаа холбооны бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх;
- Ашиг, орлогоо нэмэгдүүлэхийн тулд технологийн хөгжилтэй мөр зэрэгцэн ажиллах хувьцаа эзэмшигчдэдээ үр өгөөжтэй байх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монголын цахилгаан холбоо ХК-нь Компанийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Аудитын тухай хууль, Засгийн Газрын тусгай сангийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай, Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2022 оны 72 дугаар тогтоол зэрэг хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Төрийн аудитын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хуулийн шинэчилсэн найруулга;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх, хяналт шалгалт хийх журам”-ийг шинэчлэн батлах тухай СЗХ-ны 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 22 дугаар тогтоол;
- Мэдээлэл харилцаа холбооны салбарт мөрдөгдөж буй эрх зүйн актууд.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/201 тоот тушаалаар “Дотоод аудитын газрын ажиллах журам, Монголын цахилгаан холбоо ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 190 дүгээр хурлын 01 дүгээр тогтоолын 14 дүгээр хавсралтаар “Монголын цахилгаан холбоо ХК-ийн дотоод аудитын журам”-ыг тус тус баталсан байна.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан бүтэц, зохион байгуулалтаар Дотоод

аудит, шинжилгээ үнэлгээний албыг татан буулгаж, Дотоод аудитын газрыг чанарын хяналтын албатайгаар баталсан байна.

Дотоод аудитын газар нь 2023 онд 11 ажил төлөвлөснөөс санхүүгийн шинжилгээ, ашиг алдагдлыг тооцох, 14 аймагт төлөвлөгөөт шалгалт хийхээс 5 аймагт хийгдээгүй хойшилж, нийт төлөвлөгөөний биелэлт 78.5 хувийн хэрэгжилттэй байна. Дотоод аудитын газар-чанарын хяналтын албанаас Инновац бизнес хөгжил, маркетинг борлуулалт, үйлчилгээ, удирдлага зохион байгуулалт, хүний нөөц, санхүү хөрөнгө оруулалт, техникийн ашиглалт үйлчилгээ гэсэн 5 чиглэлээр хяналт шалгалтыг явуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар албан даалгавар хүргүүлсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2023 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн №23-01/24 дүгээр шалгалтын удирдамжаар Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2022 оны удирдлага, санхүү, аж ахуй, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийсэн байна. Аудитын явцад баримтын шалгалтын тайлан, үр дүн гараагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/72 тоот тушаалаар компанийн үйл ажиллагаанд мөрдөх НБББББ-ийг баталсан байна.

Тус компанийн мөрдөж байгаа НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад зарим талаар нийцээгүй, үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

НБББББ-т шинээр гарсан стандарт, хууль, заавар журмын дагуу өөрчлөлт оруулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,975.8 сая төгрөгөөр буюу 38.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	308,008.6	751,782.9	443,774.3
Авлага	4,349,038.6	8,119,591.6	3,770,553.0
Бусад санхүүгийн хөрөнгө	1,500,000.00	1,500,000.0	-
Бараа материал	3,216,553.5	3,437,925.4	221,371.9
Үндсэн хөрөнгө	39,666,462.3	54,206,606.9	14,540,144.6
Нийт хөрөнгийн дүн	49,040,063.0	68,015,906.8	18,975,843.8
Өр төлбөр	12,371,870.6	17,648,166.6	5,276,296.0
Эздийн өмчийн дүн	36,668,192.4	50,367,740.2	13,699,547.8
Өр төлбөр эзэмшигчдийн өмчийн дүн	49,040,063.0	68,015,906.8	18,975,843.8

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 443.7 сая төгрөгөөр өссөн нь банкин дах дансны үлдэгдэл 104.1 сая төгрөг, охин компанийн дансны үлдэгдэл 339.6 сая төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалсан;
- Авлагын дансны үлдэгдэл 3,770.6 сая төгрөгөөр өссөн нь бусад авлага 373.9 сая төгрөг, дансны авлага 1,568.4 сая төгрөг, урьдчилж төлсөн зардал, тооцоо 1,830.9 сая төгрөгөөр тус тус өсөж, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 2.6 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан;
- Бараа материалын дансны үлдэгдэл 221.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 7,595.7 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, үйл ажиллагаанд 7,374.3 сая төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 14,540.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 1,392.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, дахин үнэлгээгээр 31,509.8 сая төгрөгөөр нэмэгдэж, ТУЗ-ын 2022 оны 179 дүгээр тогтоолын дагуу 462.5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл акталж, 17,899.5 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан;
- Өр төлбөрийн үлдэгдэл 5,276.3 сая төгрөгөөр өссөн нь ногдол ашгийн өглөг 0.03 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 72.5 сая төгрөг, урьдчилж орсон орлого 224.7 сая төгрөгөөр тус тус буурч, хүүгийн өглөг 174.3 сая төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 207.3 сая төгрөг, татварын өр 478.6 сая төгрөг, урт хугацаат зээл 1,209.0 сая төгрөг, хойшлогдсон татварын өр 1,504.1 сая төгрөг, дансны өглөг 2,000.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан;
- Эздийн өмчийн дүн 13,699.6 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 8,840.6 сая төгрөг, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга 4,830.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд 28.9 сая төгрөгийн ашигтай ажилласнаас шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Компанийн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор нийт орлогыг 20,938.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 20,898.2 сая төгрөгөөр, 10.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоож, хөрөнгө оруулалтын арга хэмжээг 3,468.6 сая төгрөгөөр баталж, зорилтот түвшний төлөвлөгөөнд тодотгол хийгээгүй байна.

Гүйцэтгэлээр 20,790.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 20,671.1 сая төгрөгийн зардал гарган, 118.9 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 20,790.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 148.1 сая төгрөг буюу 0.7 хувиар тасарсан нь дуудлагын төвийн орлого 108.1 сая төгрөг, КаТв, ОТТ, Лавлах үйлчилгээний орлого 231.8 сая төгрөг, интернетийн орлого 1,029.5 сая төгрөг, суурин утасны үйлчилгээ 2,252.9 сая төгрөгөөр тус тус тасарч, ФТТН үйлчилгээний орлого 59.3 сая төгрөг, хүү болон валютын ханшийн зөрүүний орлого 75.4 сая төгрөг, МТС Сервис ХХК-ийн орлого 196.4 сая төгрөг, бусад орлого 3,143.1 сая төгрөгөөр тус тус давсанаас шалтгаалжээ. Нийт зардлын гүйцэтгэл 20,671.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 227.1 сая төгрөг буюу 1.1 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь үйл ажиллагааны өртөг 248.5 сая төгрөг, үйл ажиллагааны бусад зардал 621.6 сая төгрөг, цалингийн зардал 935.9 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, МТС сервис үндсэн ҮА-ны зардал 52.5 сая төгрөг, Үндсэн бус үйл ажиллагааны зардал 215.4 сая төгрөг, элэгдлийн зардал 1,311.0 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 19 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 1,180.3 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 28.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 18.8 сая төгрөгөөр илүү байгаа нь тайлант хугацаанд 227.1 сая төгрөгийн зардлыг дутуу зарцуулсан, орлогын албан татварт 60.1 сая төгрөг илүү төлсөн нь нөлөөлжээ.

Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2022 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн байна.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Компанийн үйл ажиллагааг сайжруулах талаар авлага, өр төлбөрийн барагдуулалт, төлбөрийн баримт, газар эзэмших эрхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно. Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж чанарын хяналтын менежер С.Сожидмаа, компанийн захирал С.Тунгалаг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхжин, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Монголын цахилгаан холбоо ХК-нь 2023 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 1/79 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний нийт зардал 20,898.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 209.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монголын цахилгаан холбоо ХК нь 690 орон тоотойгоор ажиллахаас 516 орон тоотой ажиллаж, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 817.9 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 14,251.6 сая төгрөгийн зөрчлөөс 14,006.3 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 245.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг шалгахад нийт 74 мэдээлэл байршуулахаас хугацаандаа оруулсан 31, оруулах мэдээлэл байхгүй 43 мэдээлэл байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант хугацаанд 134.9 сая төгрөгийн бараа, ажлыг босго үнэд багтаан 7 удаагийн гэрээ байгуулан шууд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил худалдан авахдаа босго үнэд багтаан гэрээг хуваасан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Бараа материалын худалдан авалтын дүнд шинжилгээ хийхэд тайлант хугацаанд нийт 43 нэр төрлийн 38.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй бараа материалд 60.9 сая төгрөгийн бараа материалыг нэмж худалдан авсан байна. Тайлант хугацаанд нийт 20.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь оны эхний үлдэгдлээс 18.0 сая төгрөгөөр бага, бараа материалын тайлант хугацааны үлдэгдэл 3,437.9 сая төгрөгт хүрч, оны эхнээс 204.0 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлсөн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас 2024 оны 08-ны өдрийн 1/358 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн 76 газрыг байгууллагын газрын гэрчилгээ, эзэмших эрхийн гэрээтэй тулгахад, шалгагдагч байгууллага нь 12 газрын гэрчилгээ, гэрээг аудитад ирүүлээгүй байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д "Улсын бүртгэлд эрхийн гэрчилгээг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, олгогдсон газрын нэгж талбарын дугаар, хэмжээ, байршлыг тэмдэглэх бөгөөд эрхийн гэрчилгээтэй холбогдсон аливаа өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна" 34.8-д "Газар эзэмших гэрээ нь эрхийн гэрчилгээний хамт хүчин төгөлдөр байх бөгөөд гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэнэ" гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй газрын эзэмших гэрчилгээгүй, гэрээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас 2024 оны 08-ны өдрийн 1/358 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн 76 газраас 12 газрын эзэмших эрхийн хугацаа дууссан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-т "Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ цахим системээр гаргах бөгөөд дараах баримт бичгүүдийг хавсаргана" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газар эзэмших эрхийн хугацааг сунгуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5. Монголын цахилгаан ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөний эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 2023 оны нийт авлагын үлдэгдлийг 2,740.0 сая төгрөг, өр төлбөрийг 7,132.1 сая төгрөгт хүргэхээр тогтоосноос нийт авлага 5,841.1 сая төгрөгт хүрч 3,101.1 сая төгрөгөөр, нийт өр төлбөр 17,629.3 сая төгрөгт

хүрч 10,561.3 сая төгрөгөөр тус тус зорилтот түвшинд тогтоосон дүнгээс илүү үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.5-т "Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгасны дагуу бууруулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

6. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөний эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 2023 оны нийт орлогыг 20,938.2 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 20,790.1 сая төгрөгийг бүрдүүлж, орлогын төлөвлөгөө 148.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3/-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах " Монголын цахилгаан холбоо ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал хоорондын онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 2 дугаар зүйлийн 2.1.2-т "ТУЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэх, компанийн үйл ажиллагааг Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж удирдан хяналт тавих..." гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

7. Он дамжсан өр төлбөрийн 295 харилцагчийн 245.3 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуудийн 71 дүгээр зүйлийн 8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.5-т "Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх; гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Он дамжсан өглөгийг барагдуулах төлөвлөгөө гарган ТУЗ-өөр батлуулан мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, өмнөх аудитын хэрэгжилт, шилэн данс, мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өр төлбөр, зардлын дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Шалгагдагч байгууллагад завсрын аудитаар 11,928.0 сая төгрөгийн 24 алдааг залруулах зөвлөмжийг асуудлын бүртгэлээр танилцуулан баталгаажуулсан ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж, үр дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 13,013.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 12.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 11,730.8 сая төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлснээс 5 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, 75.3 хувийн биелэлттэй, 1,270.1 сая төгрөгийн 9 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх, санхүүгийн программыг шинэчлэх, төлбөрийн и баримттай холбоотой өгсөн зөрчлийг давтан гаргаж, зөвлөмжийн хэрэгжилт 2.9 хувийн биелэлттэй, нийт хэрэгжилт 68.2 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	12,352.1	2	12,352.1	100.0
Албан шаардлага	7	11,730,751.0	5	8,831,659.60	75.29
Зөвлөмж	9	1,270,065.8	3	36,231.10	2.85
Нийт дүн	18	13,013,168.9	10	8,880,242.8	68.2

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй албан шаардлагыг биелүүлээгүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, Санхүүгийн программыг шинэчлэх төсвийг 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан тул дахин албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар НБББББ, санхүүгийн программын шинэчлэл, эрсдэлийн сан болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, дотоод хяналтын үйл ажиллагааны үр дүн, авлага өр төлбөрийн барагдуулалт, ТӨБЗГ-аас хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, зэргийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,279.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 5,279.0 сая төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба Алдаа 41-д “Алдаа нь санхүүгийн тайлангийн элементүүдийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулга, болон тодруулгатай холбоотойгоор үүсэж болох юм. Санхүүгийн тайлан нь материаллаг алдааг эсвэл аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний тухайлсан тодорхой нэг толилуулгад хүрэхийн тулд санаатайгаар хийсэн материаллаг бус алдааг агуулж байвал СТОУС-тай үл нийцнэ. Тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг. Гэвч заримдаа, материаллаг алдааг дараагийн тайлант үе хүртэл илрүүлж чаддаггүй бөгөөд тэдгээр өмнөх үеийн алдааг тухайн дараагийн тайлант үеийн санхүүгийн тайланд толилуулсан зэрэгцүүлэгдэх мэдээлэлд засварладаг.” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй дараах ажил гүйлгээг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Орон нутаг гэж бүртгэгдсэн нийт 91 толгой 12.3 сая мянган төгрөгийн мал амьтадын үнийг зах зээлийн үнээр бүртгэж тайлагнаагүй, холбогдох анхан шатны бүртгэлийг хөтлөөгүй;
- Олгохоор тооцсон цалин хөдөлмөрийн хөлсийг, цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварын тайланд тайлагнахдаа 6 ажилтны цалин хөлсийг 0.6 сая төгрөгөөр илүү, 6 ажилтны цалин хөлсийг 3.3 сая төгрөгөөр дутуу, нийт 3.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг;
- Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах ажил гүйлгээгээр үүссэн хойшлогдсон өр төлбөрөөс 68.3 сая төгрөгийн ажил гүйлгээг хойшлогдсон хөрөнгө дансанд, дахин үнэлгээний гарз дансанд 62.6 сая төгрөгөөр, нийт 130.9 сая төгрөгөөр ажил гүйлгээг илүү бүртгэж тайлагнасныг;
- Харилцах дансны болон хадгаламжийн хүүгийн орлого 4.0 сая төгрөгийн орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд тайлагнаагүйгээс 0.4 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд тайлагнаагүйг;
- Тайлант онд хойшлогдсон хөрөнгийн үлдэгдлийг хуримтлагдсан ашиг дансанд 151.4 сая төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөг дансанд 25.5 сая төгрөг, нийт 176.9 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж тайлагнасныг;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан тайлангийн ТТ-02 маягтын СТ-30 тайлангийн тодруулгад ажил гүйлгээг дутуу бүртгэснээс татварт төлөх өглөгийг 100.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг;
- Гадаад валютаар илэрхийлсэн өр төлбөрт ханшийн тэгшитгэлийг алдаатай бүртгэснээс 0.4 сая төгрөгөөр өр төлбөрийг дутуу тайлагнасныг;
- Санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайланд тайлагнасан 40.3 сая төгрөгийн татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлыг, тайлант оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд тайлагнаагүйн улмаас аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардлыг илүү тооцсоныг;
- Хадгаламж барьцаалсан 1,209.0 сая төгрөгийн урт хугацаат банкны зээлийг бусад богино хугацаат өр төлбөрөөр бүртгэж тайлагнасныг;
- Банкны тулган баталгаажуулах захидлын дүнгээс мөнгөн хөрөнгийн журналд бичилт хийгдээгүй 11 дансны 2,824.5 сая төгрөг, гүйлгээ балансын дүнгээс зөрүүтэй 33,676.9 сая төгрөг, нийт 2,858.2 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг;

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

- Банкны тулган баталгаажуулалтаас мөнгөн хөрөнгийн журналын оны эцсийн үлдэгдлийн дүн 0.3 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг;
- Дорноговь аймгийн салбар нь 2014 онд хийгдсэн НББ-т бүртгэгдээгүй, шилэн кабелийн холболтын 13.6 сая төгрөгийн авлагыг төлж барагдуулсан дүнгээс, хувь хэрэглэгчдийн он дамжсан 1.7 сая төгрөгийн авлагыг хааж, тайлан онд хийгдээгүй интернэтийн ажлын орлогоор 11.9 сая төгрөгийг бүртгэж хаасныг;
- Дорноговь аймаг дахь салбар нь 3 төсөвт байгууллагын ирүүлсэн саналаар 2-8 сарын 0.9 сая төгрөгийн интернэтийн төлбөрийн урьдчилан төлснийг өглөгөөр бүртгэснийг;
- Эм ти си сервис ХХК-ийн мөнгөн хөрөнгийн журналд бүртгэгдсэн оны эхний үлдэгдэл 59.5 сая төгрөгийн үлдэгдэл нь тулган баталгаажуулах захидлын дүнгээр 41.2 сая төгрөг буюу 18.3 сая төгрөгөөр зөрүүтэй, мөнгөн хөрөнгийн журналын бичилт хийгдээгүй 3 дансны оны эхний үлдэгдэл 0.3 сая төгрөгөөр, нийт 18.6 сая төгрөгийн зөрүүтэйг;
- Шалгагдагч байгууллагын зарласан худалдан авах ажиллагаанд шалгарсан 4 байгууллагын 711.2 сая төгрөгийн гэрээг www.tender.gov.mn цахим хуудсанд байршуулаагүйг;
- Эм ти си сервис ХХК нь өр төлбөрийн 1 харилцагчийн 1.5 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүйг;
- Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төв аймгийн салбарын мөнгөн хөрөнгөнд биет тест хэрэгжүүлэхэд нярвын жижиг мөнгөн сангийн үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр дутагдсаныг;
- Аудитад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, тооллого хийж тооцоо бодсон актыг тус тус ирүүлээгүйн улмаас элэгдлийн зардлыг үнэн тооцсон эсэхийг тодорхойлох боломжгүйг тус тус залруулав.

Аудитаар нийт 15,887.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 5.2 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 7,735.2 сая төгрөгийн зөрчилд 19 албан шаардлага хүргүүлж, 8,147.5 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 15,887.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 15,678.9 сая төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төв аймгийн салбарын бараа материал, үндсэн хөрөнгөнд түүвэр тооллого хийхэд 0.9 сая төгрөгийн үнэтэй 1 ширхэг зургийн камертай аппарат, "борлуулах бараа" дансанд нэг бүрийн үнэ нь 0.01 сая төгрөгийн үнэтэй 4 ширхэг универсал удирдлага, нийт 5 ш 0.9 сая төгрөгийн үнэ бүхий бараа материал, үндсэн хөрөнгө биетээр байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.4-д "Үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ." гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллогоор дутагдсан хөрөнгийг буруутай ажилтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

2. Тайлант онд үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхэлж байгаа 87 ажилтанд 1.5 сая төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-т "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын хөнгөлөлтийг илүү тооцож олгосныг буруутай ажилтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тайлант онд давхардсан тоогоор 126 ажилтны томилолтоор ажилласан хугацаанд 1.3 сая төгрөгийн хоол, унааны нэмэгдлийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ" 2.2.3-т "Хоолны зардал" гэж гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хоол, унааны нөхөн олговрыг давхардуулан олгосныг буруутай ажилтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4. Тайлант онд баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулахад 1.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулсан зардлыг буруутай ажилтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Шалгагдагч байгууллагын ашиглаж байгаа Prosoft программ нь жижиг дунд аж ахуйн нэгжид ашиглах зөвшөөрөлтэй программ тул нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээг дэлгэрэнгүй гаргах, аудитыг гүйцэтгэхэд ихээхэн цаг хугацаа зарцуулж, хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т "Төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11-т "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх.", Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын зөвлөмжийг биелүүлээгүй, санхүүгийн программыг шинэчлээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төв аймгийн салбарын хөрөнгөнд тооллого хийхэд актлагдсан боловч үргэлжлүүлэн ашиглаж байгаа оффис ширээ 3 ширхэг, төмөр шкаф 5 ширхэг, хар сандал 15 ширхэг, Dell дэлгэц 1 ширхгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, хөрөнгийн ашиглалтын карт салбарт байхгүйгээс үндсэн хөрөнгөнд тулгалт хийх боломжгүй байна.

Энэ нь 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3-ын 2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглагдаж буй үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Тус компанийн 1998-2006 онуудад төлөхөөр бүртгэж тайлагнасан нийт 146.2 сая төгрөгийн ногдол ашгийг он удаан жил төлөөгүй, үлдэгдлээр бүртгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.10-т "Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна." гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг олгоогүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Дорноговь аймгийн салбар нь шатахууны зардал болох 1.0 сая төгрөгийг жолоочийн замын хуудасгүй, шахахууны тооцоог бодохгүйгээр бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар дугаар 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Замын хуудасгүй, шатахууны тооцоо бодоогүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5. Тайлант онд 25 ажилтны цалин хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын тайланд тайлагнахдаа 16.2 сая төгрөгөөр илүү, 29 ажилтны 13.1 сая төгрөгөөр дутуу, нийт 29.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

6. Тайлант онд 2 ажилтны цалин хөлснөөс суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг нийгмийн даатгалын тайланд 0.8 сая төгрөгөөр илүү, 1 ажилтны цалин хөлснөөс 0.06 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, нийт 0.8 сая төгрөгийг байгууллагаас төлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

7. Тайлант онд Албан томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад давхардсан тоогоор 56 хүнд 19.6 сая төгрөгийн томилолт илүү олгосон.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 6 дугаар тогтоолоор баталсан хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4-т "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтыг илүү олгосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

8. Тайлант онд 29 хүнд нийт 14.1 сая төгрөгийн албан томилолтыг анхан шатны бүрдэл дутуу олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 6 дугаар тогтоолоор баталсан хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4-т "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэлгүй томилолтын мөнгө олгосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

9. Тайлант онд шатахууны 3,873.37 литр нийт 9.5 сая төгрөгийн шатахууныг замын хуудасгүй олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Замын хуудасгүй шатахуун олгосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

10. Эм Ти Си сервис ХХК нь 8 харилцагчийн нийт 22.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

11. Монголын цахилгаан холбоо ХК-ийн орон нутгийн 22 салбарын 1179 харилцагчийн нийт 1,172.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

12. Монголын цахилгаан холбоо ХК нь 467 харилцагчийн нийт 3,497.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох шаардлага хүргүүлэв.

13. Монголын цахилгаан холбоо ХК-ийн орон нутгийн 21 салбарын 750 харилцагчийн нийт 71.6 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

14. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 261 харилцагчийн нийт 2,588.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

15. Тайлант хугацаанд нийт 1439 удаагийн 120.2 сая төгрөгийн орлогын гүйлгээг авлагын дансанд бичилт хийхгүйгээр мөнгөн сууриар бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө." санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогыг мөнгөн сууриар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

16. Тайлант онд байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг зөрчиж 9 ажилтанд нийт 18.7 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг илүү, гүйцэтгэх захиралд эргэн төлөх график, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 15.0 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа, нийт 33.7 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 9.1.5 дахь заалтад "ажилтны хүсэлтээр 3 хүртэлх сарын үндсэн цалинг тухайн жилдээ эргэн төлөгдөх нөхцөлөөр харилцан тохиролцож урьдчилан олгож болно" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод журам, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй цалингийн урьдчилгаа илүү олгосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

17. Өмнөх аудитаар НБББББ-т өөрчлөлт оруулах хууль, эрх зүйн акт болон стандартын өөрчлөлтийг боловсруулж, нэмэлт зардал гаргахгүйгээр НБББББ-т өөрчлөлтийг тусган мөрдөж ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг",

18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." 20 дугаар зүйлийн 20.2.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, НБББББ-ийг шинэчилж боловсруулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

18. Дорноговь аймгийн салбар нь нийт харилцагчдаас 10 төсөвт байгууллагын борлуулалтын дүнг түүвэрлэн цахим төлбөрийн баримттай тулган шалгахад НӨАТ-ын тайлан 2.1 сая /НӨАТ-тай дүн/ төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Борлуулалтын дүн цахим төлбөрийн системийн баримтаас зөрүүтэй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

19. Тайлант онд 31 ажилтны цалин хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын тайланд тайлагнахдаа даатгуулагчаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг 2.3 сая төгрөгөөр илүү, 29 даатгуулагчийг 1.3 сая төгрөгөөр дутуу, 25 даатгуулагчийн ажил олгогчоос төлөх шимтгэлийг 2.2 сая төгрөгөөр илүү, нийт 5.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж төлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх заалт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын шимтгэлийг алдаатай бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлбөрийн баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 100 иргэн, байгууллагын дүн 1,326.2 сая төгрөгөөр илүү, 1506 иргэн байгууллагын дүнг 2,740.2 сая төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй." гэж заасныг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөрийн цахим системд бүртгэсэн баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Дорноговь дах салбарын хөрөнгийн тооллогоор 8 нэр төрлийн 1.0 сая төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэж заасныг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооллогоор илэрсэн бараа материалын үлдэгдлийг орлогоор бүртгэж тайлагнаж байх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Дорноговь аймгийн салбар нь албан ирсэн буцсан хоногийг бүртгэж баталгаажуулаагүй томилолтын хуудсаар давхардсан тоогоор 7 ажилтанд нийт 1.0 сая төгрөгийг томилолтын зардлыг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Томилолтын тооцоог анхан шатны баримтыг үндэслэн тооцож олгож байх

4. Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А-1/1343 дугаар албан бичгээр Монголын цахилгаан холбоо ХК-ийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг 5.1 сая төгрөг байхаар тогтоосон боловч ногдол ашгийн өглөгөөр бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 341 дүгээр тогтоолыг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчид төвлөрүүлэх ногдол ашгийг өглөгөөр бүртгэж, тайлагнаж байх

5. Газар эзэмших эрхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын нягтлан бодох бүртгэлд Газар 80 ширхэг эзэмших эрх бүртгэлтэй боловч Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 1/358 дугаар албан бичгийн хавсралтаар шалгагдагч байгууллагын 2073943 регистрийн дугаараар Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд 76 газар бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага гэж заасныг мөрдөөгүй", санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын эзэмших эрхийг үнэн зөв анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлагнаж байх.

6. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Он дамжсан 320 харилцагчийн нийт 4,073.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх." гэж заасныг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан авлагын үлдэгдлийг бүрэн барагдуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орон нутаг гэж бүртгэгдсэн нийт 91 толгой 12.3 сая мянган төгрөгийн мал амьтадын үнийг зах зээлийн үнээр бүртгэж тайлагнаагүй, холбогдох анхан шатны бүртгэлийг хөтлөөгүй байна.	1	12,280.0	1	12,280.0	-	-	1	12,280.0	-	-	-	-
Олгохоор тооцсон цалин хөдөлмөрийн хөлсийг, цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан татварын тайланд тайлагнахдаа 6 ажилтны цалин хөлсийг 0.6 сая төгрөгөөр илүү, 6 ажилтны цалин хөлсийг 3.3 сая төгрөгөөр дутуу, нийт 3.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	3,887.9	-	-	1	3,887.9	1	3,887.9	-	-	-	-
Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах ажил гүйлгээгээр үүссэн хойшлогдсон өр төлбөрөөс 68.3 сая төгрөгийн ажил гүйлгээг хойшлогдсон хөрөнгө дансанд, дахин үнэлгээний гарз дансанд 62.6 сая төгрөгөөр, нийт 130.9 сая төгрөгөөр ажил гүйлгээг илүү бүртгэж тайлагнасан байна.	1	130,964.5	-	-	1	130,964.5	1	130,964.5	-	-	-	-
Харилцах дансны болон хадгаламжийн хүүгийн орлого 4.0 сая төгрөгийн орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд тайлагнаагүйгээс 0.4 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардлыг санхүүгийн тайлангийн	1	399.9	1	399.9	-	-	1	399.9	-	-	-	-

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан


орлогын дэлгэрэнгүй тайланд тайлагнаагүй байна.													
Тайлант онд хойшлогдсон хөрөнгийн үлдэгдлийг хуримтлагдсан ашиг дансанд 151.4 сая төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөг дансанд 25.5 сая төгрөгийг, нийт 176.9 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж тайлагнасан байна.	1	176,919.4	-	-	1	176,919.4	1	176,919.4	-	-	-	-	
Аж ахуйн нэгжийн орлогын албан тайлангийн ТТ-02 маягтын СТ-30 тайлангийн тодруулгад ажил гүйлгээг дутуу бүртгэснээс татварт төлөх өглөгийг 100.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	100,335.8	-	-	1	100,335.8	1	100,335.8	-	-	-	-	
Гадаад валютаар илэрхийлсэн өр төлбөрт ханшийн тэгшитгэлийг буруу хийж 0.4 сая төгрөгөөр өр төлбөрийг дутуу тайлагнасан байна.	1	397.6	-	-	1	397.6	1	397.6	-	-	-	-	
Санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайланд тайлагнасан 40.3 сая төгрөгийн татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлыг тайлант оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд тайлагнаагүй улмаас аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардлыг илүү тооцсон байна.	1	40,306.8	-	-	1	40,306.8	1	40,306.8	-	-	-	-	
Хадгаламж барьцаалсан 1,209.0 сая төгрөгийн урт хугацаат банкны зээлийг бусад богино хугацаат өр төлбөрөөр бүртгэж тайлагнасан байна.	1	1,209,000.0	-	-	1	1,209,000.0	1	1,209,000.0	-	-	-	-	
Банкны тулган баталгаажуулах захидлын дүнгээс мөнгөн хөрөнгийн журналд бичилт хийгдээгүй 11 дансны 2,824.5 сая төгрөг, гүйлгээ балансын дүнгээс зөрүүтэй 33,676.9 сая төгрөг, нийт 2,858.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	1	2,858,218.2	-	-	1	2,858,218.2	1	2,858,218.2	-	-	-	-	

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Банкны тулган баталгаажуулалтаас мөнгөн хөрөнгийн журналын оны эцсийн үлдэгдлийн дүн 0.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна	1	331.2	-	-	1	331.2	1	331.2	-	-	-	-
Дорноговь аймгийн салбар нь 2014 онд хийгдсэн НББ-т бүртгэгдээгүй, шилэн кабелийн холболтын 13.6 сая төгрөгийн авлагыг төлж барагдуулснаас хувь хэрэглэгчдийн он дамжсан 1.7 сая төгрөгийн авлагыг хааж, тайлан онд хийгдээгүй интернэтийн орлогоор 11.9 сая төгрөгийг бүртгэж хаасан байна.	1	13,552.0	-	-	1	13,552.0	1	13,552.0	-	-	-	-
Дорноговь аймаг дахь салбар нь 3 төсөвт байгууллагын ирүүлсэн саналаар 2-8 сарын 0.9 сая төгрөгийн интернэтийн төлбөрийн урьдчилан төлснийг өглөгөөр бүртгэсэн байна.	1	935.0	-	-	1	935.0	1	935.0	-	-	-	-
ЭМ ТИ СИ сервис ХХК-ийн мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл мөнгөн хөрөнгийн журналд 59.5 сая төгрөгөөр бүртгэсэн нь тулган баталгаажуулах захидлын дүнгээр 41.2 сая төгрөг буюу 18.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Мөнгөн хөрөнгийн журналын бичилт хийгдээгүй 3 дансны оны эхний үлдэгдэл 0.3 сая төгрөгөөр, нийт 18.6 сая төгрөгийн зөрүүтэй байна.	1	18,596.6	-	-	1	18,596.6	1	18,596.6	-	-	-	-
Шалгагдагч байгууллагын зарласан худалдан авах ажиллагаанд шалгарсан 4 байгууллагын 711.2 сая төгрөгийн гэрээг tender.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй байна.	1	711,215.2	1	711,215.2	-	-	1	711,215.2	-	-	-	-
Эм Ти Си сервис ХХК нь өр төлбөрийн 1 харилцагчийн 1.5 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	1,460.8	-	-	1	1,460.8	1	1,460.8	-	-	-	-
МЦХ ХК-ийн Төв аймгийн салбарын мөнгөн хөрөнгөнд биет тест хэрэгжүүлэхэд нярвын жижиг мөнгөн сангийн үлдэгдэлд биет тест	1	195.0	-	-	1	195.0	1	195.0	-	-	-	-

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

гүйцэтгэхэд 0.2 сая төгрөгийг дутагдуулсан байна.												
Аудитад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, тооллого хийж тооцоо бодсон актыг тус тус ирүүлээгүйн улмаас элэгдлийн зардлыг үнэн тооцсон эсэхийг тодорхойлох боломжгүй байна.	1	-	-	-	1	-	1	-	-	-	-	-
Дүн	18	5,278,995.8	3	723,895.2	15	4,555,100.7	18	5,278,995.8	-	-	-	-



6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 100 иргэн, байгууллагын дүн 1,326.2 сая төгрөгөөр илүү, 1506 иргэн байгууллагын дүнг 2,740.2 сая төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.	1	4,066,426.2	-	-	-	-	1	4,066,426.2	-	-	-	-
Монголын цахилгаан холбоо ХК-ийн Дорноговь дах салбарын хөрөнгийн тооллогоор 8 нэр төрлийн 1.0 сая төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгээгүй байна.	1	1,028.5	-	-	-	-	1	1,028.5	-	-	-	-
Шалгагдагч байгууллагын ашиглаж байгаа Prosoft программ нь жижиг дунд аж ахуйн нэгжид ашиглах зөвшөөрөлтэй программ тул нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээг дэлгэрэнгүй гаргах, аудитыг гүйцэтгэхэд ихээхэн цаг хугацаа зарцуулж, хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

МЦХ ХК-ийн Төв аймгийн салбарын хөрөнгөнд тооллого хийхэд актлагдсан боловч үргэлжлүүлэн ашиглаж байгаа офисс 3 ширхэг ширээ, төмөр шкаф 5 ширхэг, хар сандал 15 ширхэг, Dell дэлгэц 1 ширхгийг дахин үнэлээгүй, нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна. Мөн хөрөнгийн ашиглалтын карт салбарт байхгүйгээс үндсэн хөрөнгөнд тулгалт хийх боломжгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
МЦХ ХК-ийн Төв аймгийн салбарын бараа материал, үндсэн хөрөнгөнд түүвэр тооллого хийхэд 0.9 сая төгрөгийн үнэтэй 1 ширхэг зургийн камертай аппарат, "борлуулах бараа" дансанд нэг бүрийн үнэ нь 0.01 сая төгрөгийн үнэтэй 4 ширхэг универсал удирдлага, нийт 5 ш 0.9 сая төгрөгийн үнэ бүхий бараа материал, үндсэн хөрөнгө биетээр байхгүй байна.	1	903.0	1	903.0	-	-	-	-	-	-	-	-
Тус компанийн 1998-2006 онуудад төлөхөөр бүртгэж тайлагнасан нийт 146.2 сая төгрөгийн ногдол ашгийг он удаан жил төлөөгүй, үлдэгдлээр бүртгэж ирсэн байна.	1	146,169.2	-	-	1	146,169.2	-	-	-	-	-	-
Дорноговь аймгийн салбар нь нийт харилцагчдаас 10 төсөвт байгууллагын борлуулалтын дүнг түүвэрлэн цахим төлбөрийн баримттай тулган шалгахад НӨАТ-ын тайлан 2.1 сая /НӨАТ-тай дүн/ төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	2,144.9	-	-	1	2,144.9	-	-	-	-	-	-
Дорноговь аймгийн салбар нь сар бүрийн нийт шатахуун зарцуулалт 1.0 сая төгрөгийг, төсөвт батлагдсан дүнгээр, жолоочийн замын хуудас хөтлөөгүй, шахахууны тооцоог	1	1,020.0	-	-	1	1,020.0	-	-	-	-	-	-




Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

бодохгүйгээр бүртгэж тайлагнасан байна.												
Дорноговь аймгийн салбар нь албан томилолтоор ажилласан ажилтны албан томилолтын зардлыг олгохдоо ирсэн буцсан хоногийг бүртгэж баталгаажуулаагүй томилолтын хуудсаар давхардсан тоогоор 7 ажилтанд 1.0 сая төгрөгийг олгосон байна.	1	1,003.1	-	-	-	-	1	1,003.1	-	-	-	-
Тайлант онд үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхэлж байгаа 87 ажилтанд 1.5 сая төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна.	1	1,516.7	1	1,516.7	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд 25 ажилтны цалин хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын тайланд тайлагнахдаа 16.2 сая төгрөгөөр илүү, 29 ажилтны 13.1 сая төгрөгөөр дутуу, нийт 29.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	29,255.9	-	-	1	29,255.9	-	-	-	-	-	-
Тайлант онд 31 ажилтны цалин хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын тайланд тайлагнахдаа даатгуулагчаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг 2.3 сая төгрөгөөр илүү, 29 даатгуулагчийг 1.3 сая төгрөгөөр дутуу, 25 даатгуулагчийн ажил олгогчоос төлөх шимтгэлийг 2.2 сая төгрөгөөр илүү, нийт 5.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж төлсөн байна	1	5,823.2	-	-	1	5,823.2	-	-	-	-	-	-
Тайлант онд 2 ажилтны цалин хөлснөөс суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг нийгмийн даатгалын тайланд 0.8 сая төгрөгөөр илүү, 1 ажилтны цалин хөлснөөс 0.06 сая төгрөгийн	1	814.3	-	-	1	814.3	-	-	-	-	-	-

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, нийт 0.8 сая төгрөгийг байгууллагаас төлсөн байна.													
Тайлант онд давхардсан тоогоор 126 ажилтны томилолтоор ажилласан хугацаанд 1.3 сая төгрөгийн хоол, унааны нэмэгдлийг давхардуулан олгосон байна	1	1,266.0	1	1,266.0	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А-1/1343 албан тоотоор Монголын цахилгаан холбоо ТӨХК-ийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг 5.1 сая төгрөг байхаар тогтоосон боловч ногдол ашгийн өглөгөөр бүртгэж тайлагнаагүй байна.	1	5,066.5	-	-	-	-	1	5,066.5	-	-	-	-	-
Албан томилолтын зардлыг анхан шатны баримттай тулган шалгахад давхардсан тоогоор 56 хүнд 19.6 сая томилолт илүү олгосон.	1	19,759.1	-	-	1	19,759.1	-	-	-	-	-	-	-
Нийт 29 хүнд 14.1 сая төгрөгийн албан томилолтыг олгохдоо анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн байна.	1	14,093.0	-	-	1	14,093.0	-	-	-	-	-	-	-
Шатахуун зарцуулалтын тайланг давтан тооцоолоход нийт 9.5 сая төгрөгийн 3,873.37 литр шатахууныг замын хуудас хөтлөхгүйгээр олгосон байна.	1	9,515.2	-	-	1	9,515.2	-	-	-	-	-	-	-
Эм Ти Си сервис ХХК нь авлагын 8 харилцагчийн 22.9 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	22,874.3	-	-	1	22,874.3	-	-	-	-	-	-	-
Монголын цахилгаан холбоо ХК-ийн орон нутгийн 22 салбарын 1179 харилцагчийн 1,172.1 сая төгрөгийн	1	1,172,077.6	-	-	1	1,172,077.6	-	-	-	-	-	-	-



Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.													
Монголын цахилгаан холбоо ХК-ийн орон нутгийн 21 салбарын 750 харилцагчийн 71.6 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	71,648.6	-	-	1	71,648.6	-	-	-	-	-	-	-
Тайлант хугацаанд нийт 1439 удаагийн 120.2 сая төгрөгийн орлогын гүйлгээг авлагын дансанд бичилт хийхгүйгээр мөнгөн сууриар бүртгэж, тайлагнасан байна.	1	120,193.8	-	-	1	120,193.8	-	-	-	-	-	-	-
Байгууллагын нягтлан бодох бүртгэлд Газар 80 ширхэг эзэмших эрх бүртгэлтэй боловч Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын 2024 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 1/358 дугаар албан бичгийн хавсралтаар шалгагдагч байгууллагын 2073943 регистрийн дугаараар Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд 76 газар бүртгэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Тайлант онд баяр ёслол тэмдэглэхэд 1.5 сая төгрөгийг зарцуулсан байна.	1	1,549.9	1	1,549.9	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг зөрчиж 9 ажилтанд 18.7 сая төгрөгийг илүү, гүйцэтгэх захиралд эргэн төлөх график, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 15.0 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа, нийт 33.7 сая төгрөгийг олгосон байна.	1	33,730.0	-	-	1	33,730.0	-	-	-	-	-	-	-
Авлагын 320 харилцагчийн 4,073.9 сая төгрөгийн он дамжсан үлдэгдлийг барагдуулаагүй байна.	1	4,073,873.1	-	-	-	-	1	4,073,873.1	-	-	-	-	-
Нийт 261 харилцагчийн 2,914.2 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг	1	2,588,471.8	-	-	1	2,588,471.8	-	-	-	-	-	-	-

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.												
Нийт 467 харилцагчийн 3,497.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна	1	3,497,632.2	-	-	-	-	-	-	1	3,497,632.2	-	-
Өмнөх аудитаар НБББББ-т өөрчлөлт оруулах хууль, эрх зүйн акт болон стандартын өөрчлөлтийг боловсруулж, нэмэлт зардал гаргахгүйгээр НБББББ-т өөрчлөлтийг тусган мөрдөж ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Дүн	29	15,887,856.1	4	5,235.6	18	4,237,591.0	6	8,147,397.3	1	3,497,632.2	-	-



6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Нийт 2 байгууллагатай, 2 нэр төрлийн 134.9 сая төгрөгийн бараа, ажлыг 7 удаагийн гэрээгээр шууд худалдан авалт хийсэн байна.	1	134,858.7	1	134,858.7	-	-
Бараа материалын худалдан авалтын дүнд шинжилгээ хийхэд тайлант хугацаанд нийт 43 нэр төрлийн 38.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй бараа материалд 60.9 сая төгрөгийн бараа материалыг нэмж худалдан авсан байна. Тайлант хугацаанд нийт 20.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь оны эхний үлдэгдлээс 18.0 сая төгрөгөөр бага бөгөөд, бараа материалын тайлант хугацааны үлдэгдэл 3,437.9 сая төгрөгт хүрч, оны эхнээс 204.0 сая төгрөгөөр өссөн байна.	1	60,949.5	1	60,949.5	-	-
Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас 2024 оны 08-ны өдрийн 1/358 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн 76 газрыг байгууллагын газрын гэрчилгээ, эзэмших эрхийн гэрээтэй тулгахад дараах 12 газрын гэрчилгээ, гэрээг аудитад ирүүлээгүй байна.	1	-	1	-	-	-
Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас 2024 оны 08-ны өдрийн 1/358 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн 76 газраас 12 газрын эзэмших эрхийн хугацаа дууссан байна.	1	-	1	-	-	-
Он дамжсан өр төлбөрийн 295 харилцагчийн 245.3 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй байна.	1	245,279.1	-	-	1	245,279.1
МЦХ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 184 дүгээр хурлын 01 дүгээр тогтоолын хавсралт № 1-аар баталсан Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөний эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 2023 оны нийт авлагын үлдэгдлийг 2,740.0 сая, нийт өр төлбөрийг 7,132.1 сая төгрөгт хүргэхээр тогтоосноос нийт авлага 5,783.1 сая төгрөгт хүрч 3,044.1 сая төгрөгөөр, нийт өр төлбөр 17,629.3 сая төгрөгт хүрч 10,561.3 сая төгрөгөөр тус тус зорилтот түвшинд тогтоосон дүнгээс илүү үлдэгдэлтэй байна.	1	13,662,377.1	1	13,662,377.1	-	-
МЦХ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 184 дүгээр хурлын 01 дүгээр тогтоолын хавсралт № 1-аар баталсан Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөөний эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 2023 оны нийт орлогыг 20,938.2 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 20,790.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу орлогын төлөвлөгөөг 148.1 сая төгрөгөөр тасалдуулсан байна.	1	148,133.8	1	148,133.8	-	-
Дүн	7	14,251,598.1	6	14,006,319.1	1	245,279.1